

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил	3
1.4. Ил уурхай.....	4
1.5. Баяжуулах үйлдвэр	6
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1. Нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл	8
2.2. Судагааны арга зүй	8
2.3. Дорноговь аймаг	8
2.1.3. Орон нутгийн удирдлага	8
2.1.4. Хүн ам.....	8
2.1.5. Боловсрол, мэдээллийн байгууллагууд.....	9
2.1.6. Ажилгүйдэл	9
2.1.7. Боловсрол.....	9
2.1.8. Хөдөө аж ахуй	9
2.1.9. Аж үйлдвэр.....	10
2.1.10. Гэмт хэрэг	10
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	11
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго	13
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
АРАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ	27

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС.....	28
Нэг. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл.....	28
Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт лавлагааны товч мэдээлэл	29
ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨЗО ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ.....	30
ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ.....	31
ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС.....	32
ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	33
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ	33
НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	33
ХЯНАЛТЫН ХУУДАС.....	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Ил уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 1-2. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд	5
Хүснэгт 1-3. Уулын ажлын төлөвлөгөө	5
Хүснэгт 1-4. Баяжуулах үйлдвэрийн календарь төлөвлөгөө	7
Хүснэгт 3-1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	11
Хүснэгт 5-1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	14
Хүснэгт 6-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Хүснэгт 7-1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	18
Хүснэгт 8-1. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 9-1. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	19
Хүснэгт 10-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 11-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 12-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 13-1. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт 14-1. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн талбайн байршил	4
Зураг 1-2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем	6

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч “Их түмэн хүрд” ХХК нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт дэвсгэрт орших MV-021559 (932.13 га) тоот тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Түмэн айл” чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрт 2015-2017 онд хайгуулын ажил гүйцэтгэсэн. Ордын бохир чулуун нүүрс бодитой болон боломжтой нөөцийг 61977.85 мян.тн, цэвэр чулуун нүүрс бодитой болон боломжтой нөөцийг 59859.99 мян.тн-р ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд ЭБМЗ-ийн 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн ХХ-18-04 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн н/10 тоот тушаалаар бүртгэж авсан байна.


Түмэн айл чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг тус ордод гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ЭБЭХ-ний Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам” зэргийг үндэслэн “Ляпислазурь эрдэнэ” ХХК боловсруулсан байна.

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хэрэгжүүлэгч:	“Их түмэн хүрд” ХХК
	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:
Улсын бүртгэлийн дугаар:	9011778053
Регистрийн дугаар:	6375839
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, Нарны зам, Жигүүр гранд оффис 5-11 тоот
Утас:	+(976) 99102445

1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил

Дорноговь аймгийн Мандах сумын төвөөс урагш 30 км, Сайншанд хотоос баруун урагш 200 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 484 км, МУ-БНХАУ хилийн Ханги-Мандал боомтоос баруун хойш 235 км-т байрлалтай.



Зураг 1-1. Төслийн талбайн байршил

1.4. Ил уурхай

Ил уурхайн хүрээ: Ордыг 860 м-ийн түвшин хүртэл ашиглах ба газрын гадаргаас доош 190 м гүн ухаш үүснэ. Нүүрсний давхаргын зузаан нь дунджаар 5-7 м юм. Уурхайн нээлтэд уул-техникийн хувьд хүндрэл гарахгүй. $У=282173.6490$ $Х=4891557.5960$ $Z=1055$ цэгээс 280 градусын азимутаар зүүн урдаас баруун хойд зүүн чиглэлд 15 метрийн ёроолын өргөнтэй хажуу хоёр хананы налуугийн өнцөг 55° байхаар нүүрсний гарш хэсгээр суналын дагуу хэвтээ траншей нэвтэрч нээнэ.

Геологийн нөөц: Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийн нөөцийг ЭБМЗ-ийн 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн хурлын ХХ-18-04 тоот дүгнэлт, нөөц хүлээн авч, бүртгэх тухай АМГТГ-ын даргын 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн №10 тоот тушаалаар бохир чулуун нүүрсний нөөц баттай /А/ зэргээр 30578.13 мян.тн, бодитой /В/ зэргээр 31399.72 мян.тн, боломжтой , нийт (А+В) зэргээр 61977.85 мян.тн, цэвэр чулуун нүүрсний нөөц баттай /А/ 29630.01 мян.тн, бодитой /В/ зэргээр 30229.72 мян.тн, нийт (А+В) зэргээр 59859.99 мян.тн-оор тус тус хүлээн авч бүртгэсэн. Тус орд нь II бүлэгт хамаарах тул үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо Уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалыг үндэслэн А зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн батлагдсан А', В зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцов. Тус ордын ил уурхайн хүрээ дэх нүүрсний нөөц баттай /А/ зэргээр 29630.02 мян.тн бодитой /В/ зэргээр 28165.8 мян.тн, нийт (А+В) зэргээр 57795.82

мян.тн байна. Ил уурхайн олборлолтын үеийн дундаж хаягдал 4.8 % буюу 2771.43 мян.тн, бохирдолт 8.36 % буюу 4598.45 мян.тн байна. Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц батлагдсан А' болон магадалсан В' зэргээр нийт 59622.86 мян.тн байна.

Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа: Түмэн айлын чулуун нүүрсний ордоос баяжуулах үйлдвэрийн хүчин чадлаас хамаарах ба жилд 1000.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 1.47 м³/тн байна. Нийт ил аргаар ашиглах уурхайн хүрээн дэх нүүрсний үйлдвэрлэлийн нөөц 59622.86 мян.тн байна.

Ил уурхайн ажиллах горим: Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн турш хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төсөлд тусгасан байна.

Хүснэгт 1-1. Ил уурхайн ажиллах горим

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	15
3	Цаг агаарын хүндрэл	хоног	14
4	Засвар үйлчилгээ	хоног	18
5	Өвлийн улирлын зогсолт	хоног	51
6	Уурхайн ажиллах хоног	хоног	270
7	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
8	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд: Доор авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр ил уурхайг байгуулж ил уурхайн хүрээн дэх уулын цул, хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлсон ба зарим нөхцөлд мөргөцгийн налууугийн хэмжээ нь хүдрийн биетийн уналын өнцгөөр тодорхойлсон байна.

Хүснэгт 1-2. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ил уурхай
1	Ил уурхайн гүн	м	190
2	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	28-35
3	Доголын өндөр	м	5
4	Ёроолын өргөн	м	15
5	Доголын налууугийн өнцөг	градус	55
6	Аюулгүйн өргөн	м	5-7
7	Уурхайн замын өргөн	м	30-45
8	Ажлын талбайн өргөн	м	30


Хүснэгт 1-3. Уулын ажлын төлөвлөгөө

№	Ашиглалтын жилүүд	Уулын цул	Нүүрс		Хөрс	Хөрс хуулалтын итгэлцүүр	
		мян.м ³	мян.м ³	мян.тн	мян.м ³	м ³ /м ³	м ³ /тн
1	I жил	1393.95	23.15	31.94	1370.80	59.22	42.92
2	II жил	1407.92	41.52	57.30	1366.40	32.91	23.85
3	III жил	3145.02	356.52	492.00	2788.50	7.82	5.67

4	IV жил	4679.81	740.51	1021.90	3939.30	5.32	3.85
5	V жил	4889.17	686.67	947.60	4202.50	6.12	4.43
6	VI жил	4507.45	751.45	1037.00	3756.00	5.00	3.62
7	VII жил	4507.45	751.45	1037.00	3756.00	5.00	3.62
8	VIII жил	4507.45	751.45	1037.00	3756.00	5.00	3.62
9	IX жил	4507.45	751.45	1037.00	3756.00	5.00	3.62
10	X жил	4507.45	751.45	1037.00	3756.00	5.00	3.62
11	Нийт	38053.11	5605.61	7735.74	32447.50	5.79	4.19

1.5. Баяжуулах үйлдвэр

Нүүрс баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, бутлан ангилах хэсэг, хүнд орчинд баяжуулах хэсэг, хаягдлын аж ахуйн хэсэг, эргэлтийн усан сан, ус дамжуулах насос, баяжмалд хадгалах хэсэг, хяналт шинжилгээний лаборатори, засвар механикийн хэсэг зэргээс бүрдэнэ.



Зураг 1-2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 80-90 %-тай ажиллах үед баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 154.3 тн байна.

$$Q_{ц} = \frac{Q_{жил} \cdot k_n}{T \cdot m \cdot n \cdot k_x} = \frac{1000000 \cdot 1}{300 \cdot 2 \cdot 12 \cdot 0.90} = 154.2 \text{ тн/ц}$$

Хүснэгт 1-4. Баяжуулах үйлдвэрийн календарь төлөвлөгөө

№	Ажиллах горим	Хэмжих нэгж	3-р жил	4-р жил	5-р жил	6-10 р жил
1	Жилд ажиллах бодит хоног	хоног	190	300	300	300
2	Жилд ажиллах бодит цаг	цаг	4560	7200	7200	7200
3	Хоногт ажиллах бодит цаг	цаг	24	24	24	24
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2	2	2	2
5	Ээлжид ажиллах бодит цаг	цаг	12	12	12	12
6	Техникийн ажлын норм	%	90	90	90	90
7	Цагийн хүчин чадал	тн/цаг	141.6	157.7	146.2	160.0
8	Хоногийн хүчин чадал	тн/хоног	3059.2	3406.3	3158.7	3456.7
9	Жилийн хүчин чадал	мян.тн/жил	581.24	1,021.90	947.60	1,037.00
10	Нэгж үйлдвэрийн хүчин чадал	мян.тн/жил	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Энэхүү бүлэгт Дорноговь аймаг болон Мандах сум, “Их Түмэн Хүрд” ХХК-ийн Довцог худаг нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд багтах багуудын нийгэм эдийн засгийн суурь мэдээллүүдийг нарийвчлан тусгав. Дорноговь аймгийн статистик мэдээллийг 2016 оны статистикийн эмхэтгэл, Статистик мэдээллийн үйлчилгээний систем <http://www.dornogovi.nso.mn/page/293>-ээс тус тус авав. Төслийн талбай орчмын малчин иргэд, өвөлжөө бууц, малчин өрхүүдээс цуглуулсан аман судалгааны мэдээллийг Эко Трейд ХХК-ийн шинжээчид 2017 оны 10 дугаар сарын 3-наас 6-ны өдөр хүртэл талбай дээр ажиллаж анхдагч буюу суурь мэдээллийг боловсруулан ашиглав.

2.2. Судагааны арга зүй

Нийгмийн төлөв байдлын суурь судалгааны хүрээнд дараах гурван түвшинг тодорхойллоо. Үүнд:

- Бүс нутгийн хэмжээнд (Дорноговь аймаг): Бүс нутгийн эдийн засгийг ерөнхий байдлаар тодорхойлсон;
- Орон нутгийн хэмжээнд (Мандах сум): Сумдуудын нийгмийн хамрах хүрээг тодорхойлохтой холбоотой асуудлуудын талаар судалж, маш дэлгэрэнгүй нарийвчлан тодорхойлсон;
- Орон нутгийн анхан шатны түвшинд: Төслийн талбай орчмын өрхүүдийн талаарх судалгааг хийж, тодорхойлон тус тайланд орууллаа.

2.3. Дорноговь аймаг

Дорноговь аймаг 1931 онд байгуулагдсан бөгөөд 14 сум, 64 багтай. 66600 орчим хүн амтай, 109,472.30 км² газар нутагтай бөгөөд сүүлийн жилүүдэд хүн ам огцом өсч байна. Аймгийн төв Сайншанд Улаанбаатар хотоос 450км-т оршдог. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог бөгөөд БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг хэсэгт монгол улсын бараа эргэлтийн ихэнх нь хийгддэг Замын-Үүд хилийн боомт байрлана. Мөн хойд, урд хоёр гүрнийг холбосон төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин сууж байна.

2.1.3. Орон нутгийн удирдлага

Засаг захиргааны хувьд 14 сум, 64 багтай. Сумдын нутгийн захиргааны байгууллага нь сумын ИТХ, Засаг дарга түүний Тамгын газраас бүрдэнэ. Бүх суманд Ерөнхий боловсролын сургууль, Хүн эмнэлэг, Соёлын төв, хувийн Мал эмнэлэг төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Аймгийн төв Сайншанд хотод аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 20 гаруй газар, хэлтэс, албад үйл ажиллагаа явуулж байна.

2.1.4. Хүн ам

Тус аймагт 2016 оны эцсийн байдлаар 20300 өрхөд 66600 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 1.64 хүн ногдож байна. Тэдний 60.6 хувь нь хот /аймгийн төв/ тосгонд, 15.2

хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Хүн амын 48.7 хувь нь эрэгтэйчүүд, 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нэг өрхөд дунджаар 3,4 хүн ногддог. Нийт 19.7 мянган ажиллагсад байгаа нь ажил эрхэлж байгаа нэг хүнд 2.6 хүн ноогдож байна. Хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр тус аймаг улсын дунджаас дээгүүр байдаг. Нийт өрхийн 15.2 хувь, хүн амын 19,6 хувь нь амьжиргааны доод түвшинээс доогуур орлоготой амьдарч байна. Ажилгүйдлийн түвшин 2.6% байна.

2.1.5. Боловсрол, мэдээллийн байгууллагууд

Дорноговь аймагт Ерөнхий боловсролын 20 сургууль, 17 дотуур байр, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 1, Төмөр замын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 1 зэрэг эрүүл мэнд, боловсролын байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит "Саранхөхөө" театр, Иргэдийн хөгжил төв, Усан спорт сургалтын төв, Нийтийн номын сан, Орон нутгийн судлах музей, Ноён хутагт Данзанравжаагийн музей, Орон нутгийн 3 телевиз, Дорноговийн мэдээ сонин зэрэг соёл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг. 2017 оны байдлаар Орон нутгийн мэдээллийн цахим хуудас <http://dtime.mn/>, Өнөөгийн Дорноговь сонин, Дорноговь сэтгүүл, D TV (Дорноговь телевиз) үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

2.1.6. Ажилгүйдэл

2016 оны байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйдлийн тоо 1503 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 276 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 357 ажилгүйдлийн тоо ногдож байна (Дүрслэл 14.2). 2000 оны байдлаар 535 ажилгүйдлийн тоо бүртгэгдсэн ба байнгын хүн амтай харьцуулахад 1 хувийг эзэлж байсан бол 2016 онд байнгын хүн ам 13 хувиар өсөхөд ажилгүйдлийн тоо 2 дахин өссөн, ажилгүйдлийн нийт хүн амд эзлэх хувь 2 дахин өссөн үзүүлэлттэй гарч байна.

2.1.7. Боловсрол

Дорноговь аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 21 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж нийт 12278 хүүхэд суралцаж, 3 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаа явуулж, 1308 хүүхэд суралцаж байна. 2000 оны байдлаар ЕБС-д 1029 хүүхэд, МСҮТ-д 757 хүүхэд суралцаж байсан бол 2016 оны байдлаар ЕБС-д 12278 хүүхэд, МСҮТ-д 1308 хүүхэдтэй болж нийт суралцагсдын тоо өссөн үзүүлэлттэй гарсан байна. Харин сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг харахад МСҮТ-д суралцагсдын тоо буурч ЕБС-д суралцагсдын тоо өссөн хандлага ажиглагдаж байна.

2011 оны үед ЕБС-д суралцагчид 9 дүгээр анги төгсөн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд элсэн суралцах хандлагатай байсан бол 2016 оны байдлаар МСҮТ-д элсэн суралцагсдын тоо 66-аар буурсан байна.

2.1.8. Хөдөө аж ахуй

2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1752.9 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 48.2 мянган толгой буюу 2.7 хувиар буурч, тэмээ 37.7 мянга, адуу 118.6 мянга, үхэр 63 мянга, хонь 758.3 мянга, ямаа 755.8 мянган толгой болжээ. Хээлтэгч малын тоог өмнөх

оныхтой харьцуулахад ижил үзүүлэлттэй байсан бол бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос бага үзүүлэлттэй байна.

2.1.9. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ 2016 оны үнээр 55.13 сая төгрөг болж өмнөх оноос өссөн нь энэ онд уул уурхай олборлох салбарын бүтээгдэхүүн /нүүрс, жонш/ үйлдвэрлэлт өссөнтэй холбоотой байна. 2008-2011 онд эдийн засгийн уналт, уул уурхайн салбарын уналттай холбоотойгоор бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ 3.4-4.3 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байжээ.

2.1.10. Гэмт хэрэг

Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 655 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.5 хувиар өссөн байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжиж буй “Их түмэн хүрд” ХХК-ний “Их түмэн хүрд нүүрсний орд” нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, тухайн газарт явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлов. Энэ үнэлгээг дараах дарааллаар гүйцэтгэв. Үүнд:

- Байгаль орчны үнэлгээний өмнөх шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;
- БОННУ-ний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5-н үндсэн үлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3-н бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3-н зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн.

Хүснэгт 3-1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас /хөрс хуулалт, олборлолт, овоолго, зам, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч	-					-		-			-

элэгдэх, эвдрэлд орох, дарагдах											
Хөрс хуулалт, хүдэр олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх	-				-			-			-
Бичил уур амьсгал өөрчлөгдөх		-		-			-			-	
Байгалийн нөөц ашиглалт											
Газрын нөөц баялаг	-				-			-			-
Газрын доорх усны нөөц	-				-					-	
Бэлчээрийн нөөц	-				-			-			-
Эрдэс түүхий эдийн нөөц	-				-			-	-		
Эрчим хүчний нөөц			-		-				-		
Байналь орчны чанарын өөрчлөлт											
Газрын доорх ус бохирдох		-		-			-				-
Гадаргы усны бохирдол		-		-			-		-		
Агаар бохирдох	-			-			-		-		
Хөрс бохирдох	-				-		-				-
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйлс											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-				-				-		
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-				-				-		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		-			-			-	-		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	-				-			-	-		
Архелоги, палентологийн олдворт нөлөөлөх	-				-			-	-		
Эдийн засаг, нийгмийн асуудал											
Татварын орлого нэмэгдэх	+				+						+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+						+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх	+				+						+
Ажлын байр нэмэгдэх	+				+						+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-						-
Нийт	20	5	1	4	17	4	5	8	4	8	8

Тайлбар:

Сөрөг нөлөөлөл. Хүчтэй /-, Дунд /-/ , Бага /-/

Нөлөөлөл байхгүй /0/

Эерэг нөлөөлөл /+/ гэсэн тэмдэглэлээр үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20, шууд бус нөлөөлөл 5 байна. Нийт нөлөөллийн 8 нь бага эрчимтэй, 5 дунд эрчимтэй, 8 хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Нийт нөлөөллийн 80.8% нь сөрөг, 19.2% нь эерэг нөлөөлөл байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Экологийн системийг бүрдүүлэгч “агаар-хөрс-ургамал-амьтан-шувуу-шавж” гэсэн нийлмэл системийг хүмүүний үйл ажиллагаа болон цаг агаарын өөрчлөлттэй уялдуулан авч үзэх хэрэгтэй.

Байгаль хамгаалах ажил нь нэгдүгээрт уурхайн ашиглалтын талбай болон уурхайн тосгон, тусгай зөвшөөрлийн талбайн байгаль орчныг хамгаалах, хоёрдугаарт хүрээлэн буй орчныг экологийн системийн бүрдлийн хувьд хамгаалах гэсэн үндсэн ойлголтоос бүрдэнэ.

Иймээс бид 2023 онд Алагтогоогийн нүүрсний ордын Хойд элдэв, Хойд алагтогоо хэсгийг ил аргаар олборлох төслийн үйл ажиллагааг орон нутгийн байгаль хамгаалах ажилтай уялдуулан явуулахдаа байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлан түүний нөлөөллийн мониторингийг хоёр түвшинд авч хянан уул уурхайн нөлөөллийг авч үзнэ.

Үүнд:

Олборлолтын төслийн байгаль хамгаалах үйл ажиллагаа, мониторинг

Хүрээлэн буй орчны буюу нөлөөллийн радиуст (экологийн системийн үйлчилэх хүрээний радиусыг биологийн төрөл зүйлээс хамааран 50-100 км зайд авч үздэг практик бий) хамаарагдах нөлөөлөлийн мониторинг зэрэг болно.

Байгаль хамгаалах ажлын хүрээнд уул уурхайн төслийн байгаль хамгаалалтын хүрээнд хамаарагдах ногоон байгууламж, хөрсний хамгаалалт багтах бөгөөд мониторингийн асуудалд агаарын чанарын хяналт, хөрсний бохирдол, орон нутгийн байгууллагын бодлогын хүрээнд шийдвэрлэн хамтран ажиллах үйл ажиллагаа багтана. Харин хүрээлэн буй орчны байгаль хамгаалалын асуудалд тус нутгийн экологийн иж бүрэн системийн хүрээнд шийдвэрлэгдлэх асуудлууд багтана.

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5-1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<i>Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах</i>									
1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа тогтсон хуваарийн дагуу хийх	Уурхайн дотоод бол нүүрс тээврийн зам дагуу	Км/мото цаг	12	-		Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
2		Тээврийн зам дагуу агаарын чанарын хэмжилтийг хийх	Шороон зам	Зун, намар	2	ОХШХ-т тусгагдсаны дагуу		Улирал тутам	
3		Хучилтгүй зам дээр тээвэр хийх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулна.	Шороон зам	ш	20	50.0	1,000.0	2023 он	

4	Олборлолтын үйл ажиллагаанаас тоосжилт бий болох	Төслийн талбайд хурдны хязгаарлалтыг дагаж мөрдөх тухай дотоод журманд тусгаж өгөх	Төслийн хэмжээнд	Батлагдсан журам	-	Үйл ажиллагааны зардалаар	Жилийн турш	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS4585:2016 Агаарын чанарын стандарт Техникийн ерөнхий шаардлага
5		Усалгааг үр дүнтэй зохион байгуулах	Төслийн талбай	Усалгаа хийсэн тоо	Тоосжилт ихтэй үед тогтмол услах	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
6	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорхи усны нөөц хомсдох	Ус ашиглах хэсгийг тоолууржуулах	Унд-ахуйн усны худаг	ш	1	Үйл ажиллагааны зардалаар	2023 он	БОНХ-ийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн А-156 дугаар тушаал
7		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулж орон нутагтай гэрээ байгуулан төлбөрийг төлөх		м ³	-	Тоолуурын заалтаар	2023 оны нэгдүгээр улирал	Усны тухай хууль
8	Унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомсдох, бохирдох	Гүний усны ашиглалтын худгийг барилгажуулах, эрүүл ахуйн бүс тогтоох		ш	1	Үйл ажиллагааны зардалаар	2023 он	БОНХАЖ-ын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А 230/127 дугаар хамтарсан тушаал
Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
9	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	ГХЗ хүссэн, олгосон талбайн	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Жилийн турш	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл	

	өртөх	үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх		тоо, хэмжээ				ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
10	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах хадгалах	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	ГХЗ хүссэн, хөрс хуулах зөвлөмж олгосон талбайн тоо, хэмжээ	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Үйл ажиллагааны зардалаар	Жилийн турш	Газар хөндөх зөвшөөрөл олгох тухай “Говийн шандаст хүлэг” ХХК-ийн дотоод журам
12	Авто машины зогсоол, засварын талбайд	Засварын талбайг хүрээтэй, хатуу хучилттай болгох	Хаягдал тос хадгалах талбай	ш	Үйл ажиллагааны зардалаар		2023 он	-
13	санамсаргүй тохиолдлоор асгаралт үүсэн хөрсөн бүрхэвчийг	Асгаралтын үе хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах	Засвар үйлчилгээний газар	ш	Үйл ажиллагааны зардалаар		2023 он	-
14	бохирдуулах	Асгаралтын үеийн журам боловсруулах	Төслийн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардалаар		2023 он	-
Ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр								
15	Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	Ургамалжилтын судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтарч гүйцэтгэх	Төслийн талбайн хэмжээнд	Улирал тутам	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу		Улирал тутам	MNS 5918 : 2008
Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								

16	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Мандах сумын нутагт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Цаг үеийн хүнд нөхцөл үүссэн үед	-	1,000.0	Жилд нэг удаа зохион байгуулж ажиллана	Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мандах сумын байгаль хамгаалагч нарын өгсөн албан зөвлөмжийг үндэслэн зохион байгуулна.
Нийт зардал мян.төг				2,000.0 мян.төг					

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Техникийн нөхөн сэргээлт	Төлөвлөгдөхгүй	Га	0	0.0	0.0	-	MNS 5915:2008, • MNS 5917:2008, • MNS 5918:2008 • MNS 17.5.1.19-92, • Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 оны А-138)
2	Биологийн нөхөн сэргээлт	Төлөвлөгдөхгүй	Га	0	0.0	0.0	-	
3	Татан буулгах хаалтад бэлтгэх	Төлөвлөгдөхгүй	Га	0	0.0	0.0	-	

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7-1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Дорноговь аймгийн Мандах сумаас төлөвлөж өгсөн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах	Дорноговь аймаг, Мандах сум	Га	-	5,000.0	2023 он	Амьтны тухай хууль БОНБНУ-ий тухай хууль
Нийт зардал /мян.төг/						5,000.0		

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8-1. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох менежментийн төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Төслийн талбайд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох өрх байхгүй.								
Нийт зардал мян.төг							0.0		

ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9-1. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
1	Биет болон биет бус өв	Соёлын өвийг хамгаалах зааварчилгааг тогтмол өгч ажиллах	Төслийн нийт ажилчдад	Шинээр ажилтан ирэх бүрт	Үйл ажиллагааны зардалаар		2023	Монгол Улсын Соёлын өвийн тухай хуулийн 27.8, 27.9 БСШУ сайд 222 дугаар тушаал	
Нийт зардал мян.төг							0.0		

АРАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилсан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Автомашины осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм,	Уурхайн талбай болон орон нутаг, улсын чанартай авто замууд	Тодорхойлох боломжгүй	Тодорхойлох боломжгүй	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг Аюулгүй ажиллагааны журам Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 5 дугаар бүлэг, Замын хөдөлгөөний дүрэм Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
2	Гал түймэр	Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжуудад	5	300.0	1,500.0	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
3	Аюултай бодис асгарах	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	Лаборатори, Уурхай, Ажилчдын байрны хэсэг дэх цэвэрлэгээний хэсэг	Шаардлагатай газруудад шинээр байрлуулах болон цэнэглэх, ШТМ-аар	Химийн бодисын шингээгч болон саармагжуулагч материалын дундаж үнэ	5,000.0	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2 дугаар бүлэг

		Ялангуяа шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах		бохирдсон хөрс саарамгжуулах талбайг барьж байгуулах					
Нийт зардал мян.төг				6,500.0 мян.төг					

АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн болон үйлдвэрийн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Тн	Дахин ашигласан болон боловсруулсан хог хаягдлын хэмжээ	-	1,000.0	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
2	Аюултай хог хаягдал	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Тн	Аюултай хог хаягдлын хэмжээ	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам
3	Ахуйн болон аюултай хог хаягдал	Батлагдсан маягт болон “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах	Төслийн хүрээнд	Тн	Жилд нэг удаа	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтөлж, тайлагнах журам
Нийт зардал мян.төг							1,000.0		

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
Хүснэгт 12-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
Агаарын чанар								
1	Агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	Төслийн хашаан дотор	Улиралд нэг удаа	2	18.5	37	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан агаарын дээжийг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	Баримтлах стандарт “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016
	Агаар дахь азотын давхар исэл /NO2/							
	Хүхэрлэг хий /SO2/			2	15.0	30.0		
	Нийт тоос /TSP/							
Хөрсний чанар								
2	Хөрсний хүнд метал	Авто зогсоол	Улиралд нэг удаа	2	30.0	60.0	Хөрсний дээжийг стандартын дагуу авч итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэх	Баримтлах стандарт: “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2008
		Авто засвар		2	30.0	60.0		
		Бутлуур		2	30.0	60.0		
		Ажилчдын хотхон		2	30.0	60.0		
		Хог хаягдлын цэг		2	30.0	60.0		
Усны чанар								

3	Усны химийн шинжилгээ	Унд ахуйн худаг	Улиралд нэг удаа	2	30.0	60.0	Усны дээжийг стандартын дагуу авч итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэх	Баримтлах стандарт: “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүйн үнэлгээ” MNS 0900:2018
		Шүүрлийн ус -1	Улиралд нэг удаа	2	30.0	60.0		
		Шүүрлийн ус -2	Улиралд нэг удаа	2	30.0	60.0		
		Малчны худаг	Улиралд нэг удаа	2	30.0	60.0		
Ургамалжилтын судалгаа								
4	Ургамлын судалгаа	Төслийн талбайн хэмжээнд	Улиралд нэг удаа	2	Үйл ажиллагааны зардалаар	Мэргэжлийн байгууллага	Ургамлын судалгааны арга зүй	
Амьтны судалгаа								
5	Амьтны судалгаа	Төслийн талбайн хэмжээнд	Улиралд нэг удаа	2	Үйл ажиллагааны зардалаар	Мэргэжлийн байгууллага	Амьтны судалгааны арга зүй	
Нийт зардал мян.төг				607.0 мян.төг				

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13-1. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он		
1	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүд	Дотоод төлөвлөлт			• Мод тарих үндэсний өдөр /4, 10 дугаар сар/
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Тонн баялаг- Нэг мод" тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх.	2,000.0	10 дугаар сар		2023 онд бид нийт 1000 мод тарихаар төлөвлөн ажиллаж байна.
	Нэмэлт арга хэмжээ	2,000.0	2023		Тухайн орон нутгийн иргэдийн тавьсан саналын дагуу орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах /өвөлжилт хүндэрсэн нөхцөлд өвс тэжээл, техник төхөөрөмж, хүн хүчний дэмжэлг үзүүлэх гэх мэт/
Нийт зардал				4,000.0	

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14-1. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Дорноговь аймаг, ЗД, БОГ	Илтгэл тайлан	Өмнө жилийн болон тухайн жилийн -БОМТ-ний хэрэгжилт	Жил бүрийн 11 сард	Дотоод төлөвлөлтөөр	Компанийн БО - ны ажилтан	Дорноговь аймаг, Сайншанд
2	БОАЖЯ	Тайлан, төлөвлөгөө	Тухайн жилийн - БОМТ-ний хэрэгжилт	Жил бүрийн 12- р сард	Дотоод төлөвлөлтөөр	БОАЖЯ	БОАЖЯ
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	ИНХ	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлыг зохион байгуулах	10 сар	Дотоод төлөвлөлтөөр	Компанийн БО-ы ажилтан	Багийн төв
Нийт зардал			0.0 мян.төг				

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг	Төлөвлөгдсөн нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	0.0
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,500.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	607.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,000.0
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0.0
Нийт зардал мян.төг		19,107.0

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

Нэг. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	“Их Түмэн Хүрд” ХХК
	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011778053
	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, ашигт малтмал, олборлолт
	Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	УБ, СБД, 2-р хороо, 5-р хороолол, Нарны зам, Жигүүр гранд оффис, 5-11 тоот,
	Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ж. Дашхорол, 99103445
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б. Отгонбаатар, 88145600
1.2	1. Төслийн нэр	Нүүрсний орд ашиглах
	Төслийн харьяаллын байршил	Дорноговь аймаг, Мандах сум
	Төслийн ангилал	
	А. Нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	Нүүрс
	Б. Ил уурхай, далд уурхай, шороон орд	Ил уурхай
	В. Баяжуулах үйлдвэр	
	Төсөл эхэлсэн огноо	2023он
	Төсөл хэрэгжих хугацаа	2023-2033 он
	Уурхайн хаалт эхлэх огноо	2033 он
	Хаалтын дараах зориулалт	Бэлчээрийн зориулалт
	ТЭЗҮ баталсан огноо	2020.01.10
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	“Хамааралгүй”
	Ажилчдын тоо	96-147
	Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Батлагдсан
	Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Түмэн айл-Нүүрс баяжуулах үйлдвэр-Цагаан суваргын уурхай-Ханги мандал боомт
	Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл	240 км
Шатахуун түгээгүүрийн тоо	ШТС-1	
Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ	100 тонн	

Тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	Гэрээгээр
---	-----------

Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт лавлагааны товч мэдээлэл

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах

№	Мэдээллийн төрөл		Мэдээлэл оруулах багана	
2.1	Тусгай зөвшөөрлийн төрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай		MV-021559 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай Ашиглалтын хугацаа 10 жил 932.13 га	
	Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа		Гэрээгээр	
	Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт Галын дүгнэлтийн огноо, дугаар		Гэрээгээр	
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2023-0, №2020/Б-143 Байгаль орчин, Аялал жуулчлалын яам	
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2023-0, “Биосфер” ХХК Байгаль орчин, Аялал жуулчлалын яам	
	Ус ашиглалтын дүгнэлтийн огноо			
	Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо		2023	
	Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах		Хавсаргав	
	Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	0.0
			Төлөвлөгөөт онд гүйцэтгэх.	0.0
		Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	-
			Төлөвлөгөөт онд гүйцэтгэх.	-
ТХГН-ийн тухай хууль, гол мөрний урсац эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Хавсаргав		

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/	
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө Урьдчилан сэргийлэх арга хэмжээ Эрсдлийн үед авах арга хэмжээ Учруулсан хор үршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	
3.2	Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	
	Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ Ахуйн хог хаягдал /хатуу шингэн/ Үйлдвэрийн хог хаягдал /хатуу шингэн/ Аюултай хог хаягдал	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	19,107,000
	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	-
	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	2,000,000
	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	0.0
	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	0.0
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн	0.0

	төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төсөв	4,000,000
	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	0.0
	Тухайн жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв.	607,000

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

*Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

*Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1.	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл 1. Тосгон 2. Дэд бүтэц(зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч г.м) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Химийн бодисын агуулахын байршил 5. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 6. Тухайн жилд хуулах хөрс 7. Гадаад, дотоод овоолго 8. Техникийн нөхөн сэргээлтийн талбай 9. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 10. Гүний худгийн байршил 11. Дүйцүүлэн хамгааллын байршил	

ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

*Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А,Б,В,Гдэх баганад” **тодорхойлсон”, “ тодорхойлоогүй”, “хамааралгүй”** гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

***Дүгнэлт** гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажил хариуцсан мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөлийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл: - бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.2 Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл: - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.3 Амьтан , ургамалд үзүүлэх нөлөөлөл: - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - Амьдрах орчинг хомсдуулах, - нөөцийг бууруулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.4 Агаарт үзүүлэх нөлөөлөл: - бохирдуулах - тоос	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.5 Түүх соёлын дурсгалт эд зүйлс: - хамгаалах - нүүлгэн шилжүүлэх	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

*Төсөл хэрэгжүүлэгч нь доорхи хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

* Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.

* Доорхи хүснэгтийн “Г” багананд БОМТ-д тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын ажил хариуцсан мэргэжилтнүүд “**хангалттай**”, “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1 Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ		тийм	тийм	
7.2 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ		тийм	тийм	
7.3 Нөхөн сэргээлтийн арга хэмжээ -Техникийн/ га, эзлэхүүн/ -биологийн / га/		тийм	тийм	
7.4 Дүйцүүлэн хамгаалалын арга хэмжээ		тийм	тийм	
7.5 Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ		тийм	тийм	
7.6 Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		үгүй	үгүй	
7.7 БО-ны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		тийм	тийм	

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

* Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А,Б,В,Г” баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлнэ.

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
8.1 Хөрс	4	-Хатуу хог хаягдлын түр цэг - шимт хөрсний овоолго -ШТМ-ийн агуулах -Засвараас гарсан гарсан	Улиралд 1 удаа Жилд 4	300,000

		машины эд анги хадгалах цэг		
8.2 Ус	2	-Унд ахуйн уснаас -Шүүрлийн уснаас	Улиралд 1 удаа Жилд 4 удаа	240,000
8.3 Ан амьтан	тогтмол	Лицензийн талбай болон нүүрс тээврийн замын дагуу	Байнгын ажиглалт хийнэ.	0.0
8.4 Ургамал	Тогтмол	-	-	0.0
8.5 Агаар	4	-Ил уурхайн салхин дээд талд -Салхин доор -Уурхайн дотоод тээврийн замын доод талд -Кемп	Улиралд 1 удаа Жилд 4 удаа	67,000